

Монгол Улсын Еронхийлогч Ц.Элбэгдорж уул уурхайн хөгжлийн гол тулгуур бvс нутаг болоод буй Омноговь аймагт ажлын айлчлал хийлээ. Онгорсон долоо хоногийн ажлын өдрvдийг дуустал буюу 1-р сарын 19-21-ний өдрvдэд vргэлжилсэн айлчлалын хvрээнд Еронхийлогч Ц.Элбэгдорж Омноговь аймгийн Цогтцэций, Ханбогд, Даланзадгад сумдаар зочилж, Тавантолгойн бvс болон Оюутолгой тослийн ажлын явцтай газар дээр нь танилцсан юм. Еронхийлогчийн айлчлалын бvрэлдэхvвнд ЭБЭХ-ний сайд Д.Зоригт , Омноговь аймгаас УИХ-д сонгогдсон Ц.Баярсайхан, Х.Бадамсvрэн гишvвд болон ЗТБХБЯ, Сангийн Яам, БОАЖЯ, НХХЯ, Еронхийлогчийн Тамгын газар, холбогдох газар, агентлагуудын албаны хvмvвс багтсан.

Айлчлалын эхний одор буюу 1-р сарын 19-ний Пvрэв гарагт Еронхийлогч Омноговь аймгийн Цогтцэций суман дахь Тавантолгойн бvсэд вйл ажиллагаа явуулж буй Тавантолгой ХК, Эрдэнэс Тавантолгой ХХК болон Энержи Ресурс компаниудын уурхайгаар зочилж, ажил байдалтай нь танилцлаа. Тавантолгой ХК буюу олны нэрлэж заншсанаар “орон нутгийн” Тавантолгой компанийн хувьд Тавантолгойн нvврсний ордын 4, 8-р амуудад олборлолт явуулдаг богоод орон нутагтаа 45 жилийн турш ажиллаж байгаа гэдгээрээ баялаг тvвхтэй. Эрдэнэс Тавантолгой ХХК-н тухайд торийн омчит компани богоод вйл ажиллагаагаа эхлээд нэг жил болж байгаа. Онгорсон нэг жилийн хугацаанд тэд хорс хуулалтаа эхлvлж, 1 сая тонн нvврс олборлож чадсанаас гадна Засгийн газрын Хvний хөгжлийн санд 338 тэрбум тогрог товлорvлсэн байна. Ухаа Худаг ордод вйл ажиллагаа явуулдаг Энержи Ресурс компанийн хувьд 2009 онд уурхайн вйл ажиллагааг эхлvлсэн богоод уурхай дагасан нийгмийн болон техникийн дэд бүтцийг цогцоор нь шийдэж, богино хугацаанд ажлын далайцаа нэмэгдvлж чадсан гол онцлогтой. Оноодор тус уурхайн хvрээнд Монголын анхны Нvврс баяжуулах вйлдвэр болон 18 мегаваттын цахилгаан станц, ус хангамжийн систем, орон сууцны хороолол гээд дэд бүтцийн олон байгууламж бий болсон байна.

Еронхийлогчийн Тавантолгойд хийсэн айлчлалтай холбоотойгоор яригдсан хамгийн гол сэдэв бол мэдээж нvврс тээвэрлэх дэд бүтцийн асуудал. Тvрvчээсээ Энержи Ресурс компани оорийн хоронгоор Тавантолгойг Гашуун Сухайтын хилийн боомттой холбосон 245 км хатуу хучилттай авто зам тавьж, Эрдэнэс Тавантолгой компани ч зэрэгцээ зам тавихаар толовлож байгаа хэдий ч улс орны ирээдvйн хөгжлийн гол тvлхэц болоод байгаа Тавантолгойн ордын нvврсийг машинаар зоож борлуулна гэдэг бvтэшгvй асуудал. Цаашлаад дэд бүтцийн асуудлыг удаан хойш тавьж алгуурласнаар олон улсын нvврсний зах зээлийн орсолдогчдоос хожимдож, нvврсний внэ цэнэ алдагдах аюул бий болоод байгааг Еронхийлогч Ц.Элбэгдорж тухайлан онцгойлсон:

- Оноодор орон нутгийн Тавантолгой, Эрдэнэс Тавантолгой, Энержи Ресурс бvгд нийлээд жилд 13 сая орчим тонн нvврс олборлож байгаа юм байна. Гэтэл ойрын хэтэд Монгол Улс Тавантолгойгоос жилдээ 60 сая хvртэлх тонн нvврс олборлож байж оноох

эдийн засгийн осолт, хогжил бий болж, ард түмэнд амласан бүхэн биелэх учиртай. Энэ их нүүрсийг автомашинаар, авто замаар эсвэл тэмээгээр зоож борлуулах гээгвй л бол дэд бүтэц, томор замын асуудлыг нэн яаравчлахгвй бол болохгвй болжээ. Тавантолгойн орд нийт 6 тэрбум тонн нүүрсний нооцтэй гээд байгаа. Жилд 60 сая тонн нүүрс олборлолоо гэж бодоход 100 жил ашиглаж болох их нооц. Харамсалтай нь одоо ердөө 10-20 жилийн дараа гэхэд нүүрс дэлхий дээр ашиглагдах уу, нүүрсний эрэлт энэ хэвээр байх уу гэдэг эргэлзээтэй болсон. Нүүрсний зах зээл 100, 100 жил байсаар байх мэт бодож, алгуурлахаа одоо болих хэрэгтэй байна. Тор оороо хурдавчлахаас гадна хувийн хэвшил дэд бүтцээ оорсдоо шийдье гэж байгаа бол бололцоотой бүх талаар дэмжээд, тодорхой хугацааны дараа оортоо шилжүүлж авах хэрэгтэй. Энэ тал дээр яамны удирдлагууд болон гишүүд нам, эвсэл гэж туйлшралгвйгээр ажил хэрэгч хандаж, хурдан шуурхай, бодитой хандаж эхэлнэ гэж найдаж байна. Дэлхий дээр ганц Тавантолгой гэлтгвй коксжих нүүрсний баялаг нооцтэй ордууд олон байна. Ялангуяа урд, хойд 2 хорш маань нүүрсний арвин их нооцтэй. Овор Монголд коксжих нүүрсний ямар их баялаг ордууд нээгдэж байгааг та бүхэн мэднэ. Зовхон ОХУ-ын Элга орд газраас оросууд оорсдоо томор зам тавилаа гэхэд л манай нүүрсний орсолдох чадвар яаж буурах нь тодорхой. Тавантолгойгоос урагшаа ба хойшоо буюу 1 ба 2-р ээлжийн томор замыг зэрэг эхлүүлэхээр болсон гэж ойлгосон, одоо үүнийгээ хурдавчлуул гэдгийг л хэлмээр байна. Дэд бүтцийн асуудал, олборлолтын хэмжээ, хүчин чадал хэр байхаас Эрдэнэс Тавантолгой компанийн хувьцааны үнэ ханш, цаашдын осолт ч шууд хамааралтай байх болно гэдгийг ЭБЭХ-ний сайд Д.Зоригт мон онцлохдоо:

- Жил бүрийн нүүрсний олборлолт, борлуулалтын хэмжээ хэр байхаас компанийн хувьцааны үнэлгээ, ханш шууд хамааралтай. Оноодор Энержи Ресурс ХХК дэд бүтцээ маш сайн шийдсэн, дээрээс нь томор замаа барьж эхлэх гэж байгаа гэсэн хүлээлттэйгээр олон улсын биржид гарсан учраас IPO маш амжилттай байж чадсан, хувьцааны үнэлгээ ч ондор байсан. Эрдэнэс Тавантолгойн IPO-г сайн байлгахын тулд томор зам үнэхээр чухал байгаа.

Тавантолгойн бүсэд ажиллахдаа нохцол байдлыг илүү оргон хүрээнд, бодитой харж, ажиглаж, ойлгохыг зорьсон гэдгээ ч Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хэлж байсан. Ер нь байгалийн баялгаа зов зүйтэй ашиглаж, зов цаг вед нь дэлхийн зах зээлд амжиж хүргэн, ард иргэдийнхээ амьдралыг дээшлүүлэхэд бодит ажил хэрэг, томор замын дэд бүтцийн яаралтай, ухаалаг шийдэл дутаж байгаа гэдэг нь айлчлалын явцад тодорхой харагдаж байлаа.

Мон одортоо Ерөнхийлогчийн айлчлалын бүрэлдэхүүн Омноговь аймгийн Цогтцэций сумын иргэдтэй уулзаж, нээлттэй яриа хэлэлцүүлэг орнүүлсэн. Нутгийн иргэдийн зүгээс голчлон ярьж байсан тоосжилт, бэлчээрийн тухай асуудал ч гэсэн оноох л дэд бүтэц, томор замын асуудал шийдэгдээгвйгээс улбаатай байгааг Ерөнхийлогч онцлон хэлсэн. Мон Омноговийн баялаг зовхон өмнийн говийнхонд хамаатай мэтээр ярьж, хэлдэг явцуу ойлголтоос салж, байгалийн баялгаа Монгол Улсын нийт ард иргэдэд хүртээх тухай ярих цаг ирснийг хэлж байсан.

Ерөнхийлогчийн айлчлал 1-р сарын 20, 21-ний өдрүүдэд Ханбогд суман дахь Оюутолгойн тосол болон Даланзадгад суманд тус тус үргэлжилсэн.